

НИЙСЛЭЛИЙН СОЁЛЫН ТӨВ ӨРГӨӨНИЙ 2026 ОНЫ I УЛИРЛЫН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

2026 оны 03 дугаар сарын 31

Улаанбаатар хот

Д/д	Стратеги төлөвлөгөө болон үндэслэж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж	Төсөв (мян, төг)	Шалгуур үзүүлэлт	Суурь түвшин	Зорилтот түвшин	Хүрсэн түвшин буюу хэрэгжилт /хүрээгүй бол тайлбар/	Гүйцэтгэлийн хувь
	1	2	3	4	5	6	7
НЭГ. БОДЛОГЫН БАРИМТ БИЧИГТ ТУСГАГДСАН ЗОРИЛТ, АРГА ХЭМЖЭЭНИЙ ХЭРЭГЖИЛТ							
Зорилт 1. .НЗДҮАХ 2.4 Үндэсний агуулга бүхий соёлын бүтээлч үйлдвэрлэлийг хөгжүүлж, хотын соёлыг дээдэлсэн иргэнийг төлөвшүүлнэ.							
1.1.1	Улаанбаатар хотын Соёлын төв өргөөг засварлан тохижуулж иргэдийн тав тухтай үйлчлүүлэх орчин нөхцөлөөр хангана	Нийслэлийн Төсөв 3,600.0	Үйл ажиллагааны хэрэгжилт хувь	50	100	НЗД-ын 340 дугаар захирамжаар Соёлын төв өргөөг засварлан тохижуулахад 3,600.0 сая төсөв батлагдсан. Энэхүү захирамжын хүрээнд 2026 оны II улиралд барилгын засврын ажил эхэлнэ.	50
Зорилт-2. НЗДҮАХ 2.5 Хөгжлөөс хэнийг ч орхигдуулахгүй байх зарчмыг баримтлан хүүхэд, гэр бүл, залуучуудыг хөгжлийг дэмжиж, идэвхтэй, бүтээлч иргэнийг төлөвшүүлж, Нэгдсэн Үндэсний Байгууллагын хүүхдийн сангийн “Хүүхдэд ээлтэй хот” санаачилгыг дэмжинэ.							
1.2.1	Өсвөр үе, залуучуудын сөрөг зан үйл, хорт зуршил, цахим дээрэлхэлт, цахим гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, хувь хүний хөгжлийг дэмжих сургалт, нөлөөллийн ажлыг зохион байгуулна.	-	Зохион байгуулсан арга хэмжээний тоо	1	2	2026.04.24-нд “Манлайлагч Гүг” сургалтын төвтэй хамтран 14-с дээш өсвөр насны хүүхдүүдэд сөрөг зан үйл, хорт зуршил, цахим дээрэлхэлт, цахим гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, хувь хүний хөгжлийг дэмжих чиглэлээ сургалт зохион байгуулахаар төлөвлөн, бэлтгэл ажлыг ханган ажиллаж байна.	50

Зорилт-3. НЗДҮАХ 2.2.6 Суралцагчийн хөгжил хамгааллын үнэлгээг 3 хувиар ахиулна.

1.3.1	Хүүхэд хөгжил, хамгааллыг сайжруулах, дэмжих чиглэлээр төрийн болон төрийн бус, бусад байгууллагатай хамтран олон талт арга хэмжээг хэрэгжүүлнэ.	-	Зохион байгуулсан арга хэмжээний тоо	-	80	Хүүхэд хөгжил, хамгааллыг сайжруулах, дэмжих чиглэлээр төрийн болон төрийн бус, бусад байгууллагатай хамтран олон талт арга хэмжээг II улиралд төлөвлөсөн.	-
1.3.2	Хүүхдийн авьяас, чадварыг хөгжүүлэх, чөлөөт цагийг үр дүнтэй өнгөрүүлэх зорилгоор секц, дугуйланд хамруулан дэмжих чиглэлээр арга хэмжээ зохион байгуулах.	-	Үйл ажиллагаа ны хэрэгжилт хувь	50	90	Нийслэлийн Соёлын төв өргөөний дэргэдэх “Хүүхэд хөгжлийн төв” нь дараах 5 чиглэлээр (Төгөлдөр хуур, хийл, драм, бүжиг, япон хэл) тогтмол сургалт явуулж 45 хүүхэд хамрагдаж байна.	50

Зорилт-4. НЗДҮАХ 2.3.2 Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг нийгмийн харилцаанд тэгш, хүртээмжтэй оролцох боломжийг нэмэгдүүлж, барилга, байгууламж, явган хүний зам гэрлэн дохиог олон улсын стандартад нийцүүлэн өөрчилнө.

1.4.1	Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг нийгмийн харилцаанд тэгш, хүртээмжтэй оролцох боломжийг нэмэгдүүлж, барилга байгууламж, явган хүний зам, гэрлэн дохиог олон улсын стандартад нийцүүлэн өөрчилнө.	-	Үйл ажиллагаа ны хэрэгжилт хувь	60	100	Хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд зориулан 2025 онд гадна талбайд налуу замыг хийж гүйцэтсэн ба 2026 онд байгууллагын дотор талд хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд зориулсан налуу замыг IV улиралд хийхээр төлөвлөсөн байна.	60
-------	--	---	---------------------------------	----	-----	---	----

Зорилт-5. НЗДҮАХ 2.5.1 Хүүхэд гэр бүлийн хөгжлийг дэмжин гэр бүлийн эерэг харилцааг бэхжүүлэх сургалт, нөлөөллийн ажлыг эрчимжүүлж, хамрагдалтыг өссөн дүнгээр 5 хувиар нэмэгдүүлнэ.

1.5.1	Жилийн 4 улирлын турш үйл ажиллагаа явуулах боломжтой Хүүхэд хөгжүүлэх төв шинээр байгуулах бэлтгэл хангах	-	Үйл ажиллагаа ны хэрэгжилт хувь	60	100	“Нийслэлийн Соёлын төв өргөө” нь “Нээлттэй тайз” төслийнхөө хүрээнд 2025 оноос эхлэн жилийн 4 улиралд сургалтаа явуулж байна. Цаашид 2026 оны III улиралд сургалтынхаа анги танхим болон сургалтын төрлийг нэмэгдүүлэхээр ажиллаж байна.	60
-------	--	---	---------------------------------	----	-----	--	----

Зорилт-6. НЗДҮАХ 3.4.2.Өвлийн улиралд жуулчдад үзүүлэх үйлчилгээг нэмэгдүүлнэ.

1.6.1	Үйлчилгээний байгууллагуудын чанар стандартыг сайжруулах арга хэмжээг зохион байгуулах.	-	Үйл ажиллагаа ны хэрэгжилт хувь	60	100	Цэвэрлэгээ үйлчилгээний стандарт, горимыг мөрдөн ажиллаж, орчны цэвэр цэмцгэр байдлыг хангах, үйлчлүүлэгчдийн сэтгэл ханамжийг нэмэгдүүлэх чиглэлээр үйлчилгээний чанарыг тогтмол сайжруулан нийт 12 үйлчилгээний ажилтан, 14 хоног тутамд тогтмол их цэвэрлэгээг хийж хэвшсэн. Мөн орчин үеийн, чанартай цэвэрлэгээний багаж хэрэгслийг нэвтрүүлж, үйлчилгээний хурд, чанарыг сайжруулснаар үйлчлүүлэгчдийн сэтгэл ханамж болон байгууллагын эерэг имижийг нэмэгдүүлсэн.	60
1.6.2	Үйлчилгээний байгууллагуудын чанар стандартыг сайжруулах сургалт зохион байгуулах	-	Үйл ажиллагаа ны хэрэгжилт хувь	60	100	Үйлчилгээний байгууллагуудын чанар стандартыг сайжруулах сургалт зохион байгуулахыг II улиралд төлөвлөсөн.	60

Зорилт-7. НЗДҮАХ 4.1 Байгалийн унаган төрх, экосистемийн тэнцвэрт байдлыг хангана.

1.7.1	Ойжуулах, ойн тэлэлт ургалтыг дэмжих, нөхөн сэргээх, хамгаалах замаар ойгоор бүрхэгдсэн талбайг нэмэгдүүлж, “Тэрбум мод” үндэсний хөдөлгөөнийг үргэлжлүүлнэ.	-	Үйл ажиллагаа ны хэрэгжилт хувь	90	100	“Тэрбум мод” үндэсний хөдөлгөөний хүрээнд Нийслэлийн соёлын төв өргөөний хамт олон 2025 онд ХУД 14-р хороо, айдсын даваанд 100 орчим модыг тарьсан. II, IV дугаар улиралд хамт олноороо очиж ойр орчмыг цэвэрлэж, усалгаа, хөрсийг сийрэгжүүлэх ажлыг төлөвлөж байна.	90
-------	--	---	---------------------------------	----	-----	---	----

Зорилт-8. НЗДҮАХ 5.1.15 Төрийн албан хаагчдад авлига, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх болон ёс зүйн зөрчлөөс сэргийлэх нөлөөллийн үйл ажиллагаа тогтмол зохион байгуулж, чадавхжуулна.

1.8.1	Ёс зүйн зөрчил болон авлига, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх нөлөөллийн үйл ажиллагааг тогтмол зохион байгуулах.	-	Үйл ажиллагаа ны хэрэгжилт хувь	90	100	Байгууллагын нийт албан хаагчдад НАТЗ-н сургалт зохион байгуулахыг III улиралд төлөвлөж байна. .	90
-------	--	---	---------------------------------	----	-----	--	----

Зорилт-9. НЗДҮАХ 5.4.2 Эрэн хайх, аврах, гал түймэр унтраах техник, тоног төхөөрөмж, багаж хэрэгслийн хангалт нэмэгдэнэ.

1.9.1	Гал түймэр унтраах болон аврах ажиллагаанд шаардлагатай багаж, тоног төхөөрөмжийн хангалтыг нэмэгдүүлэх.		Үйл ажиллагааны хэрэгжилт хувь	80	100	Аваарын гарцны тэмдэг тэмдэглэгээ хийсэн. ХАБ-ын мэдээллийн самбар, байгууллагын аваарын схем зураг хийгдэж байгаа.	80
-------	--	--	--------------------------------	----	-----	---	----

ХОЁР. ХУУЛИАР ОЛГОСОН ЧИГ ҮҮРГИЙН ХҮРЭЭНД ХЭРЭГЖҮҮЛЭХ ЗОРИЛТ, АРГА ХЭМЖЭЭ

Зорилт 1. “Хүний нөөцийн удирдлагын манлайллаар хангах” зорилтын хүрээнд

2.1.1	Байгууллагын албан хаагчдыг мэргэшүүлэх сургалтад хамруулна.	-	Сургалтад хамрагдсан хүний тоо	3	5	Шилэн дансны сургалт - 2 албан хаагч, Худалдан авах ажиллагаа - 5 албан хаагч хамрагдсан. Тэнцвэржүүлсэн үнэлгээний карт: стратегийн хэмжүүр, зорилт, санаачлага, төсөв, хариуцлагыг нэг тогтолцоонд холбох нь - 3 албан хаагч,	50
2.1.2	Байгууллагын албан хаагчдын нийгмийн баталгааг хангах төлөвлөгөө гаргаж, хэрэгжүүлэх, нийгмийн асуудлыг шийдвэрлэнэ.	-	Тэтгэмж авсан ажилтны тоо	2	2	Тэтгэвэрт гарсан ахмад настнуудад хүндэтгэл үзүүлэхэд 7,000,000 төгрөг зарцуулсан байна.	100
2.1.3	Байгууллагын ажилтан, албан хаагчдад зориулсан эрүүл мэндийн сургалт зохион байгуулж, нарийн мэргэжлийн эмч нарын урьдчилан сэргийлэх үзлэгт хамруулна.	-	Үйл ажиллагааны хэрэгжилт хувь	90%	100%	- Нийт албан хаагчдыг эрт илрүүлэгийн үзлэг шинжилгээнд Улсын нэгдсэн төв I дүгээр эмнэлэгтэй хамтран ажиллах гэрээ байгуулан “Эрүүл мэндийг дэмжих төв”-ийн 253,000 төгрөгийн багцын урьдчилан сэргийлэх үзлэг шинжилгээнд нийт 72 албан хаагчийг хамруулан ажилласан. Үүнд: цусны ерөнхий шинжилгээ, элэг, цөсний үйл ажиллагаа, өөх тосны солилцоо, бөөрний үйл ажиллагаа, цусан дахь сахар, шээсний ерөнхий шинжилгээ, хэвлийн эхо, нүд, зүрхний бичлэг, эмчийн ерөнхий үзлэг багтсан байна. - Нийслэлийн хүрээ амаржих газрын урьдчилан сэргийлэх үзлэгт байгууллагийн 19 эмэгтэй албан хаагчдыг хамруулсан.	100

2.1.4	“Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөр 2024-2030 он” үйл ажиллагааны хэрэгжилтийг ханган ажиллана.	-	Үйл ажиллагаа ны хэрэгжилт хувь	80	100%	Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтийг хангаж, байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгаж, хэрэгжилтийг хангаж ажиллаж байна.	80
2.1.5	“Төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх үндэсний хөтөлбөр 2024-2030 он” хүрээнд үйл ажиллагааны төлөвлөгөө боловсруулж, хэрэгжилтийг ханган ажиллана.	-	Үйл ажиллагаа ны хэрэгжилт хувь	80	100%	Төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтийг хангаж ёс зүйг дүрмийг баримтлан ажиллаж байна. 2026 оны I улиралд байгууллагын албан хаагчдын дунд ёс зүйн зөрчил бүртгэгдээгүй байна.	80
2.1.6	Жендэрт суурилсан үндэсний хэмжээний аяныг зохион байгуулах, жендэрийн хэвшмэл ойлголтыг өөрчлөх нөлөөллийн үйл ажиллагааг хэвлэл мэдээллийн байгууллагуудтай хамтран видео контент хэлбэрээр олон нийтэд түгээнэ.	-	Үйл ажиллагаа ны хэрэгжилт хувь	-	80%	Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хууль, Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хуулийн хэрэгжилтийг ханган ажлын хүрээнд “Харилцан хүндэтгэе” “Хайраа хайрлая, хандлагаа өөрчилъе. хамтдаа үлгэрлэе” уриаг Жендэрийн тэгш эрхийн талаарх 3 пост бэлтгэн байгууллагын сошиал платформоор дамжуулан мэдээлэл түгээв.	80
2.1.7	Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хуулийн хэрэгжилтийг ханган гамшгаас хамгаалах төлөвлөгөөг боловсруулж,	-	Үйл ажиллагаа ны	-	100%	“Гамшгийн үед нүүлгэн шилжүүлэх журам”-ыг хэрэгжүүлэх хүрээнд Зарлан мэдээллийн дуут дохионы зааврын дагуу НСТӨ нь 2026 оны 03 дугаар сарын 26-ны өдрийн 16:00 цагт бэлэн байдал, албан хаагчдын оролцоон хангаж ажиллаа. Өдөр	80

	хэрэгжилтийг хангаж, ажиллана		хэрэгжилт хувь			тутмын зааварчилгааг тогтмол өгч ажиллаж байна.	
2.1.8	Монгол бичгийн үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтийг хангаж, албан хаагчдын Монгол бичгийн ур чадварыг нэмэгдүүлэх	-	Үйл ажиллагааны хэрэгжилт хувь	80	90	Монгол бичгийн үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтийг хангаж, бүх албан хаагчдыг Монгол бичгийн сургалтанд хамруулсан.	80
2.1.9	Байгууллагын шаардлагатай журмуудыг шинээр болон шинэчилж боловсруулах, хэрэгжилтийг хангах, журмын хяналтын тогтолцоог сайжруулах.	-	Үйл ажиллагааны хэрэгжилт хувь	-	90%	Байгууллагын шаардлагатай журмуудыг шинээр болон шинэчилж боловсруулах, хэрэгжилтийг хангах, журмын хяналтын тогтолцоог сайжруулан IV улиралд ажиллахаар төлөвлөсөн.	-

Зорилт 2. Мэдээллийн технологийн бодлогын хэрэгжилтийг зохион байгуулах, систем хөгжүүлэх, мэдээллийн сан бүрдүүлэх, статистик мэдээ гаргах, хэрэглэгчдийг мэдээллээр хангана.

2.2.1	Байгууллагын мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай хууль, шилэн дансны хуулийн хэрэгжилтийг хангаж, байгууллагын үйл ажиллагааг иргэд, олон нийтэд нээлттэй мэдээлж ажиллана.	-	Шилэн дансны хуулийн хэрэгжилтийг хангасан байна.	Шилэн дансны тухай хуулийн дагуу тайлант хугацаанд 41 мэдээллийг байршуулж ажилласан.	Шилэн дансны тухай хуулийн дагуу 2025 онд 171 мэдээллийг байршуулж ажиллалаа.	Төсөв, санхүүгийн ил тод байдлын хангаж, төсвийн хөрөнгийн батлагдсан төлөвлөгөө, зарцуулалтын сар улирлын мэдээг цахимаар Нийслэлийн төрийн санд өгч, шилэн дансанд тухай бүр байршуулж, байгууллагын сайтад тавьж, шилэн дансны цахим хуудсанд 41 мэдээ мэдээллийг тухай бүр тайлагнан мэдээлж ажиллалаа. Нийслэлийн Засаг даргын “Мэдээллийн ил тод байдлыг хангах талаар авах зарим арга хэмжээний тухай” 2012 оны А/606 дугаар захирамжийн дагуу цаг үеийн мэдээллийн самбарт өдөр тутмын	60
-------	--	---	---	---	---	---	----

						ажил, тоглолтын график, ажлын дуудлага байрлуулж, шинэ мэдээ мэдээллээр хангаж, байгууллагын www.stu.ub.gov.mn хаягт 40, цахим хаягт 43 мэдээлэл оруулж тогтмол ажиллуулж байна.	
2.2.2	Байгууллагын www.stu.ub.gov.mn домайн хаягтай цахим хуудасны мэдээллийг тогтмол шинэчилж, баяжуулах, хэвийн үйл ажиллагаа, аюулгүй байдлыг хангаж, ил тод байдлын тухай хуулийг баримталж хэрэглэгчдийг мэдээллээр хангана.	-	Ил тод байдлын шалгуур үзүүлэлтийн хэрэгжилтийн хувь	80%	90%	Нийслэлийн Соёлын Төв Өргөө нь 2026 оны эхний улиралын хугацаанд веб сайт, пэйж хуудас, youtube сувагт тоглолтын болон цаг үеийн мэдээллийг тухай бүрд нь видео, фото мэдээг нийт 42 мэдээ оруулснаас 18 видео бичлэг, 24 фото зурагаар мэдээлэл оруулсан байна.	70
2.2.3	Байгууллагын үйл ажиллагааны үр дүнд бий болдог захиргааны болон албан ёсны статистикийн мэдээллийн бэлэн байдлыг сайжруулах.	-	Үйл ажиллагааны хэрэгжилт хувь	-	90	Байгууллагын үйл ажиллагааны статистик, мэдээллийг үйл ажиллагааны чиглэл, үйлчлүүлэгчийн, албан хаагчдын мэдээллүүдийг нэгтгэн соёл урлагийн газарт улирал тутам болон жилийн эцсийн байдлаар хүргүүлж байна.	-
2.2.4	Хяналт, мониторинг KPI тогтолцоог сайжруулж, олон улсын үнэлгээний систем нэвтрүүлэх ажлыг эхлүүлнэ.	-	Үйл ажиллагааны хэрэгжилт хувь	-	90	“Байгууллагын стратегийн төлөвлөлт ба тэнцвэржүүлсэн үнэлгээний картыг нэвтрүүлэх нь” сургалтанд хамрагдсан. Сургалтын хүрээнд байгууллагын өнөөгийн төлөв байдлыг тодорхойлох үнэлгээг хийж гүйцэтгэн, стратегийн төлөвлөгөөгөө сайжруулахаар төлөвлөж байна.	-

2.2.5	Түрээслэгчдийн сэтгэл ханамжийн судалгаа хийж, дүгнэлтийг үйл ажиллагаандаа хэрэгжүүлж, MNS ISO 9001:2016 - чанарын менежментийн тогтолцооны стандартын нэвтрүүлэх ажлыг эхлүүлнэ.	-	Сэтгэл ханамжийн судалгааны үр дүнгийн хэрэгжилтийг хангасан баяа.	80	90	Түрээслэгчдийн сэтгэл ханамжийн байдалд судалгаа хийж, дүгнэлтийг үйл ажиллагаандаа хэрэгжүүлж, MNS ISO 9001:2016 чанарын менежментийн тогтолцооны стандартыг нэвтрүүлэх зорилгоор НСТӨргөөний “А” болон “Г” байрны түрээслэгч байгууллагуудын дунд сэтгэл ханамжийн судалгааг 2026 оны I.II-р улиралд цаасан болон цахим хэлбэрээр явуулан ажиллаж байна. Жилийн эцэст судалгааг нэгтгэж байгууллагын цахим хаягт байршуулна.	80
2.2.6	Байгууллагын вэб хуудсыг шинэчлэн, орчин үеийн шинэ программ нэвтрүүлэх	-	Үйл ажиллагааны хэрэгжилт хувь	-	90	Байгууллагын вэйб сайт хийлгэх талаар мэргэжлийн байгууллагын үнийн санал судалгаа хийж байна.	-
2.2.7	Байгууллагын брэнд бүүк хийлгэж, байгууллагын өнгө төрхийг шинэчлэх	-	Үйл ажиллагааны хэрэгжилт хувь	-	90	Байгууллагын брэнд бүүк болон вэйб сайт хийлгэх талаар мэргэжлийн байгууллагын үнийн санал судалгаа хийж байна.	-
Зорилт 3. Гадаад харилцаа, хамтын ажиллагааг хөгжүүлнэ.							
2.3.1	Гадаад орнуудын болон найрамдалт хотуудын соёлын өдрүүдийн соёл урлагийн арга хэмжээг хамтран зохион байгуулна.	-	Зохион байгуулагдсан арга хэмжээний тоо	1	2	Гадаад орнуудын болон найрамдалт хотуудын соёлын өдрүүдийн соёл урлагийн арга хэмжээг III, IV улиралд зохион байгуулахаар төлөвлөсөн.	50

Зорилт 4.Төсөв, санхүүгийн хэрэгжилтийг зохион байгуулах, зохицуулна.

2.4.1	Барилга байгууламжийн дулаан, цахилгаан, ус хангамж, хог тээвэр болон лифтний засвар үйлчилгээний холбогдох аж ахуйн нэгжтэй гэрээ байгуулж, төлбөрийг цаг хугацаанд нь барагдуулж найдвартай ажиллагааг хангаж ажиллана.	600,000,000	Үйл ажиллагааны хэрэгжилт хувь	100%	29%	Барилга байгууламжийн дулаан, цахилгаан, цэвэр бохир ус, хог тээвэр, лифтний засвар үйлчилгээг хангах талаар аж ахуй нэгж байгууллагуудтай гэрээ байгуулж, тэдгээрийн хэвийн үйл ажиллагааг хангаж 175,880,502,4 мянган төгрөгийн төлбөрийг төлж ажиллаа.	29
2.4.2	Байгууллагад шаардлагатай багаж техник хэрэгсэл, Хөдөлмөр хамгааллын хэрэгсэл урсгал засварын материал худалдан авч засвар үйлчилгээг хийх.	519,680,0	Үйл ажиллагааны хэрэгжилт хувь	100%	23%	Байгууллагад шаардлагатай багаж техник хэрэгсэл, Хөдөлмөр хамгааллын хэрэгсэл урсгал засварын материал авахад 120,735,020.58 төгрөг зарцууллаа.	23
2.4.3	Батлагдсан төсвийг зориулалтын дагуу хэмнэлттэй, үр дүнтэй зарцуулж, өр авлага үүсгэхгүй байх, хуулийн хугацаанд мэдээ тайланг холбогдох байгууллагад хүргүүлж ажиллах.	3,041,128.1	Үйл ажиллагааны хэрэгжилт хувь	100%	100%	Төсвийн хөрөнгийг зориулалтын дагуу, хэмнэлттэй, үр ашигтай зарцуулах зарчмыг баримтлан цалингийн зардал, ашиглалтын зардлыг батлагдсан төсвийн хүрээнд зохистой төлөвлөн гүйцэтгэж байна. Ажилтнуудын цалин хөлсийг хугацаанд нь олгож, холбогдох Нийгмийн даатгалын шимтгэл-ийг хуульд заасан хугацаанд бүрэн төлж барагдуулж байна.	100

Зорилт 5. Нийслэлийн иргэдэд соёл урлагаар үйлчлэх, түрээсийн гэрээ байгуулах, биелэлтийг хангуулах, орлогыг гэрээний хугацаанд бүрдүүлэх ажлыг зохион байгуулна

2.5.1	Нийслэлийн Засаг даргын 2013 оны 01 дүгээр сарын 18-ны өдрийн А/33 дугаар захирамжийн биелэлтийг хангуулна.	-	Үйл ажиллагаа ны хэрэгжилти йн хувь	100%	100%	1.2026.03.19-нд НЗДТГ, “КОП 17 ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ, БҮТЭЭН БАЙГУУЛАЛТЫН ГАЗАР” ОНӨААТҮГ-аас зохион байгуулсан “COP17” сургалт 2.Нийслэлийн Гэмт Хэргээс Урьдчилан Сэргийлэх Ажлыг Зохицуулах Салбар Зөвлөлөөс зохион байгуулсан “Монгол улсын төрийн далбааг мандуулж, буулгах” ёслолын арга хэмжээ 3.2026.03.30-нд НЗДТГ-ын шуурхай хурлыг амжилттай зохион байгуулсан бөгөөд нийт 3 удаагийн арга хэмжээнд 5 цагийн бэлтгэл сургуулилт тайз засал хийгдэж, 8 цагийн 24,000,000 төгрөгийн арга хэмжээг үнэ төлбөргүй хамтран зохион байгуулж ажиллалаа.	100
2.5.2	Нийслэлийн өмчийн барилга байгууламж, эд хөрөнгийг аж ахуйн нэгж, иргэдэд зориулалтын дагуу түрээслүүлэх, түрээсийн орлогыг гэрээний хугацаанд бүрдүүлнэ.	498,800.8	Түрээсийн орлогоор	1,197,39 9.0	3,100,00 0.0	2026 оны I улиралд Соёлын төв өргөөний “Г” байранд үйл ажиллагаа явуулж буй нийт 35 иргэн, байгууллага, аж ахуйн нэгжид зориулалтын дагуу түрээслүүлэн, түрээсийн орлогыг гэрээний хугацаанд бүрдүүлэн ажиллаж байна. I улирлын байдлаар түрээсийн орлогоор 498,800.8 мянган төгрөг төвлөрүүлсэн байна	60

2.5.3	Их танхимыг Соёл урлагийн тоглолт, арга хэмжээнд төлбөртэй ашиглуулна.	-	Түрээсийн орлогоор	652,000.0	1,100,000.0	I улирлын байдлаар их танхимыг иргэд, аж ахуйн нэгж байгууллагуудад соёл урлагийн тоглолт, арга хэмжээнд түрээсэлсэн орлогоор 309,817.0 мянган төгрөгийг бүрдүүлж үйл ажиллагааны зардлаа санхүүжүүлж ажиллаж байна	60
2.5.4	Үндэсний их баяр наадмын хүндэтгэлийн 105 жилийн ойн тоглолтыг хамтран зохион байгуулна.	-	Зохион байгуулагдсан арга хэмжээний тоо	1	1	Үндэсний их баяр наадмын хүндэтгэлийн 105 жилийн ойн тоглолт III улиралд зохион байгуулагдахаар төлөвлөгдсөн.	-
2.5.5	Нийслэл хот үүсэж байгуулагдсаны түүхт 387 жилийн ойн хүндэтгэлийн концертыг хамтран зохион байгуулна.	-	Зохион байгуулагдсан үзвэр арга хэмжээний тоо	1	1	Нийслэл хот үүсэж байгуулагдсаны түүхт 386 ойн тоглолт IV улиралд зохион байгуулагдахаар төлөвлөгдсөн.	-
ГУРАВ. ТӨРИЙН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЧАНАР, ХҮРТЭЭМЖИЙГ САЙЖРУУЛАХ ЗОРИЛТ АРГА, ХЭМЖЭЭ							
Зорилт 1. Нийслэлийн өмч ашиглалтын бүрэн бүтэн байдлыг хангаж үйлчилгээ явуулах таатай орчныг бий болгоно							
3.1.1	Байгууллагын “А” байрны хувцасны өлгүүрийн бүрэн засварыг хийж гүйцэтгэнэ.	-	Үйл ажиллагааны хэрэгжилтийн хувь	-	90	Байгууллагын “А” байрны засварын ажлыг II улиралд төлөвлөж байна	60
3.1.2	Байгууллагын “А” хэсгийн 3 давхрын урд, хойд жигүүрийн коридорын засварлаж, албан хаагчдын ажиллах таатай орчныг бүрдүүлж ажиллана.	-	Үйл ажиллагааны хэрэгжилтийн хувь	80	100	НЗД ын 340 дугаар захирамжаар “Соёлын төв өргөө”-нд шаардлагатай тоног төхөөрөмжинд 500сая төсөв хувиарласан. Байгууллагын засварын ажлыг II улиралд төлөвлөж байна	80

3.1.3	Байгууллагын “А” байрны 1-3 давхрын хуучирсан хаалгануудыг сольж, дулаан алдагдлыг бууруулан орчин нөхцөлийг сайжруулна.	-	Үйл ажиллагааны хэрэгжилтийн хувь	-	90	Байгууллагын “А” байрны засварын ажлыг III улиралд төлөвлөж байна	60
3.1.4	Байгууллагын “Г” байрны гадна болон дотор талд иж бүрэн камержуулах ажлыг хийж гүйцэтгэж ажиллана.	-	Үйл ажиллагааны хэрэгжилтийн хувь	80	90	НЗД ын 340 дугаар захирамжаар “Соёлын төв өргөө”-нд шаардлагатай тоног төхөөрөмжинд 500сая төсөв хувиарласан. Энэхүү захирамжын хүрээнд худалдан авах тендерийн ажил зарлагдана.	80
3.1.5	Байгууллагын “А” байрны их танхимд тоглолт арга хэмжээнд зориулан тайзны зориулалтын хар хулдаас авна.	-	Үйл ажиллагааны хэрэгжилтийн хувь	-	90	НЗД ын 340 дугаар захирамжаар “Соёлын төв өргөө”-нд шаардлагатай тоног төхөөрөмжинд 500сая төсөв хувиарласан. Байгууллагын засварын ажлыг III улиралд төлөвлөж байна	-
3.1.6	Байгууллагын зохион байгуулагддаг арга хэмжээнд зориулан богино долгионы shure брэндийн 6 ширхэг микрофон худалдан авна.	-	Дууны тоног төхөөрөмж ний тоо	-	4	НЗД ын 340 дугаар захирамжаар “Соёлын төв өргөө”-нд шаардлагатай тоног төхөөрөмжинд 500сая төсөв хувиарласан. Энэхүү захирамжын хүрээнд шинэ тоног төхөөрөмж худалдан авахыг III улиралд төлөвлөж байна.	-

2026 онд нийт 3 чиглэлийн хүрээнд 15 зорилтын хүрээнд 42 арга хэмжээ төлөвлөсөн.

Дундаж хувь: 52%

Төлөвлөгөөний биелэлттэй танилцсан:
“Нийслэлийн соёлын төв өргөө” ОНӨӨАТҮГ Захирал

Л.АРИУНТУЯА

Төлөвлөгөөний биелэлттэй хянасан:
Захиргаа, удирдлагын хэлтсийн дарга

Ч.ХИШИГСҮРЭН

Төлөвлөгөө тайлагнасан:
Гэрээ, тайлан мэдээ хариуцсан мэргэжилтэн

А. БЯМБАДОЛГОР